



НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

᠒᠐᠒5 оны 1᠐ сарын ᠐᠒ өдөр

Дугаар А ᠐᠒᠑

Улаанбаатар хот

「Нийслэлийн Сүхбаатар дүүргийн “Мандам”
өрхийн эрүүл мэндийн төвийн эргэлтийн бус хөрөнгийг
данснаас дансанд шилжүүлэн бүртгэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам"-ын 9 дүгээр зүйлийн 9.2 дахь хэсэг, Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2025 оны А/126 дугаар тушаалын хавсралтаар баталсан "Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс"-ын 2025 оны 09 дүгээр сарын 19-ний өдрийн 08 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй хавсралтад заасан 240,000.00 (хоёр зуун дөчин мянга) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг холбогдох дансанд шилжүүлэн, алдаатай бүртгэлийг залруулахыг Нийслэлийн Сүхбаатар дүүргийн “Мандам” өрхийн эрүүл мэндийн төв (С.Сайнаа)-д зөвшөөрсүгэй.

2.Хөрөнгийг нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартыг баримтлан бүртгэж, өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг Сүхбаатар дүүргийн “Мандам” өрхийн эрүүл мэндийн төв (С.Сайнаа)-д үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, удирдлагын хэлтэс (Т.Оюунтуул)-т даалгасугай.

ДАРГА *В. Оюунмаа* В.ОЮУМАА





Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2025 оны 10 дугаар сарын 01 - ны өдрийн 10 дугаар тушаалын хавсралт

Данснаас дансанд шилжүүлэх хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Сүхбаатар дүүргийн "Мандам" ерхийн эрүүл мэндийн төв

Д/Д	Хөрөнгийн нэр	Марк, дугаар, үзүүлэлт	Ашигласан жил	Чанар байдал	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Бүртгэх анхны		Хуримтлагдсан элэгдэл /2025 оны ... сарын ...өдрийн байдлаар/	Үлдэгдэл үнэ	Дансны нэр	
							Нэгж үнэ	Нийт үнэ			Шилжүүлэх данс	Бүртгэх данс
1	Цүнх	хар	3	хэвийн	ш	1	150,000	150,000.00	53,125.00	96,875.00	тавилга эд хогшил	хангамжийн материал
2	Зөврийн повер банк	20000	3	хэвийн	ш	1	90,000	90,000.00	31,875.00	58,125.00	машин тоног төхөөрөмж	хангамжийн материал
	Дүн							240,000.00	85,000.00	155,000.00		